



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

УИХ-ын Төсвийн байнгын хорооны захиалга, ҮАГ, аймгийн аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын хуулиар тодорхойлсон Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан.



**Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан
зориулалтын дагуу зарцуулсан байна.**

Засгийн газрын тусгай сан ”Мэргэжлийн боловсрол, сургалтыг
дэмжих сан”-гийн үйл ажиллагаа, зарцуулалтын үр дүн

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

/"Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан"/

Тайлан бэлтгэсэн: Дарга, тэргүүлэх аудитор Б.Авирмэд Аудитын менежер Ж.Энхжаргал Аудитор Т.Намжил Шинжээч Я.Зунгарав 2016 оны 10 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317, 7045-3721, 70453799 дугаарын утсаар харилцана уу. Хаяг: Увс аймгийн Аудитын газар Улаангом сум 3 баг аймгийн Засаг даргын тамгын газрын байр	Агуулга Товчилсон үгийн тайлал	1-2 3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
	Ерөнхий мэдээлэл	5
	Бүлэг 1: Хууль, эрх зүйн зохицуулалт оновчтой байна.	6
	1.1 Сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.	6
	1.2 Засгийн газрын 2015 оны 477 тоот тогтоолоор батлагдсан журмын дагуу үйл ажиллагаа явагдаж байна.	6-7
	1.3 Сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм, журмууд нь бусад хууль, тогтоомжтой нийцэж байна.	7
	Дүгнэлт	7
	Бүлэг 2: Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөхөд шаардлагатай мэдээллийг хүргүүлж ажиллажээ.	8
	2.1 Сангийн хөрөнгийг төлөвлөхөд шаардлагатай мэдээллийг ХЯ-нд хүргүүлсэн байна.	8
	2.2 Тухайн асуудал манай аймгийн түвшинд хамааралгүй байна.	8
	Дүгнэлт	8-9
	Зөвлөмж	9
	Бүлэг 3: Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулсан байна.	10
	3.1 Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцсэн байна.	10
	3.2, 3.3 дах асуудлуудын хүрээнд Увс аймагт тодорхой төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.	10
	3.4 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн санхүүжилт бүрэн олгогдоогүй байна.	10-11
	Дүгнэлт	11

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

/”Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”/

	Зөвлөмж	11
	Бүлэг 4: Дотоодын хяналт үр дүнтэй байна.	12
	4.1 Дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдсэн байна.	12
	4.2 Сангийн үйл ажилагаанд мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт хийгдээгүй байна.	12
	4.3 Шилэн дансны тухай хууль хэрэгжсэн байна.	12
	Дүгнэлт	12
	<i>Холбогдох байгууллагын санал</i>	13
	<i>Аудитын газраас өгөх тайлбар</i>	14

Товчилсон үгийн тайлал:

УИХ – Улсын Их Хурал

ҮАГ – Үндэсний Аудитын газар

БОАЖГ- Байгаль орчин аялал жуулчлалын газар

ТХШС – Төрийн хяналт шалгалтын стандарт

ТБОНӨХБАҮХАТХ- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль

ХЯ-Хөдөлмөрийн яам

ИТХ- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

УИХ-ын Төсвийн байнгын хорооны захиалга, ҮАГ-ын нэгдсэн удирдамж, аймгийн Аудитын газрын 2016 оны ажлын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Засгийн газрын тусгай сангийн тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиудын хэрэгжилт, ”Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”-гийн үйл ажиллагаа, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд хийлээ. Үүнд:

- Хууль, эрх зүйн зохицуулалт нь үйл ажиллагааг бүрэн хангаж байгаа эсэх
- Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж байгаа эсэх
- Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулж, үр дүн гарч байгаа эсэх
- Дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Хамарсан хүрээ

Аудитад Улаангом политехник коллежийн суралцагсдад 2015 он, 2016 оны хагас жилд олгогдсон тэтгэлэг, санхүүгийн болон бусад холбогдох баримт материалыг хамрууллаа.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандартыг ашиглахын зэрэгцээ захиалагч байгууллагуудын төсөл арга хэмжээний төлөвлөлтийн баримт материалд судалгаа хийх, хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, тодруулга авах, гүйцэтгэгч байгууллагын тайлан, холбогдох баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горимын дагуу биет болон баримтат нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Нийцлийн аудитыг аймгийн Аудитын газрын аудитор Т.Намжил, шинжээч Я.Зунгарав нар хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар нийт 26 санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналттай холбогдсон харилцааг зохицуулж байна.

“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуулийн 21-26 дугаар зүйлийг үндэслэн 2010 онд Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан байгуулагдаж Засгийн газрын 2011 оны 117 тоот тогтоолоор “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг баталсан байна.

“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуульд заасны дагуу сангийн санхүүгийн удирдлагын үүргийг Хөдөлмөрийн сайд эрхлэх бөгөөд сангийн хөрөнгийн зарцуулалтад боловсрол, санхүү, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл хяналт тавьж ажиллаж байна.

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн
/“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”/

Бүлэг1: Хууль, эрх зүйн зохицуулалт оновчтой байна.

1.1. Сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 21.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг 2011 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 117 тоот тогтоолоор, “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”-ыг Засгийн газрын 2007 оны 294, 2015 оны 477 тоот тогтоолоор тус тус баталсан байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог аймгийн хэмжээнд төлөвшүүлэх, дэмжин хөгжүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын 2015 оны А/04 тоот тогтоолоор аймгийн ИТХ-ын дэргэдэх “Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал хариуцсан түр хороо”-ны бүрэлдэхүүн, зохион байгуулах ажлын удирдамжийг баталжээ. Увс аймагт “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан” 2015 онд байгуулагдсан байна.

Засгийн газрын 2011 оны 117 тоот тогтоолыг үндэслэн аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны А/37-тоот тогтоолын гуравдугаар хавсралтаар “Увс аймгийн Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг баталжээ.

1.2. Засгийн газрын 2015 оны 477 тоот тогтоолоор батлагдсан журмын дагуу үйл ажиллагаа явагдаж байна.

Засгийн газрын 2015 оны 477 тоот тогтоолоор баталсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”-ын 3.2-д “Сургалтын байгууллага нь суралцагчийн тухайн сарын ирцийн мэдээллийг энэхүү журмын хавсралтад заасан маягтын дагуу тооцон нэгтгэж, дараа сарын 5-ны өдрийн дотор мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу Увс аймгийн Улаангом политехник коллежийн сургалтын алба суралцагчдын ирцийн бүртгэлийг ХЯ-д хүргүүлж байна. Аудитад хамрагдсан онуудад суралцагчдын ирц дараах байдалтай байна.

Улаангом политехник коллежийн 2015, 2016 оны элсэлтийн тоо болон тэтгэлэгт хамрагсадын судалгааг харуулав

2014-2015 оны хичээлийн жилд					
Бүлэг	Мэргэжлийн боловсрол олгох сургалт	Техникийн боловсрол олгох сургалт	Мэргэжлийн сургалт	Нийт	Үүнээс /тэтгэлэгийн нас/
1-р анги	348	114	155	617	477
2-р анги	317	142	67	526	347
3-р анги	312	47		359	272
Бүгд	977	303	222	1502	1096
Бүлэг	2015-2016 оны хичээлийн жилд				

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

/”Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”/

1-р анги	310	148	120	578	488
2-р анги	310	90	0	400	297
3-р анги	291	0	0	291	272
Бүгд	911	238	120	1269	1057
Нийт дүн	1888	541	342	2771	2153

Дээрх судалгаагаар 2015 онд 1096 суралцагч, 2016 онд 1057 суралцагч нийт 2153 суралцагч “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”-гийн тэтгэлэгт хамрагдсан байна.

1.3. Сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм, журмууд нь бусад хууль, тогтоомжтой нийцэж байна.

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.
2. Засгийн газрын 2015 оны 477 тоот тогтоолоор батлагдсан журмын дагуу үйл ажиллагаа явагдаж байна.

Бүлэг 2: Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөхөд шаардлагатай мэдээллийг хүргүүлж ажиллажээ.

2.1. Сангийн хөрөнгийг төлөвлөхөд шаардлагатай мэдээллийг Хөлмөрийн яаманд хүргүүлсэн байна.

Улаангом политехник коллеж нь 2015 оны 10 дугаар сар хүртэл Засгийн газрын 2007 оны 294 дугаар тогтоолын 6-д “Тэтгэлгийг тухайн жилд суралцах хүний дундаж тоонд үндэслэн тооцож холбогдох сургуулийн жилийн төсөвт тусгана.” гэж заасны дагуу аймгийн Улаангом политехник коллеж тухайн жилд суралцах хүний дундаж тоонд үндэслэн тооцож төлөвлөлт хийж 2015 оны 10-р сар хүтэл аймгийн төрийн сангаар дамжуулан авч олгож байжээ. Харин 2015 оны 10 дугаар сараас эхлэн тэтгэлэгт хамрагдах сурагцагчдын ирцийн бүртгэлийн мэдээг Хөдөлмөрийн яаманд хүргүүлсний дагуу суралцагчдын нэрийн дансанд тэтгэлэг нь орж байна.

Түүнчлэн “Санхүүгийн дэмжлэгийн хувь хэмжээг тогтоох тухай” Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөлийн 2011 оны 02 тоот тогтоолоор мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд оруулах санхүүгийн дэмжлэгийн хувь хэмжээг тогтоож, сангийн дэмжлэгийг зарцуулах, хуримтлал үүсгэх чиг үүргийг тодорхой зааж өгсөн байна.

Гэтэл аймгийн ИТХ-аас 2015 оны А/37 тоот тогтоолоор баталсан журмын дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг зохион байгуулах Увс аймгийн салбар зөвлөлийг /цаашид “Салбар зөвлөл” гэх/ байгуулжээ. Уг Салбар зөвлөл нь санд орлого бүрдүүлэх, үйл ажиллагааг идэвхжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны А/37-тоот тогтоолоор баталсан “Увс аймгийн Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

/“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”/

бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 1.3-д “Сангийн тухайн жилийн орлого зарлагын төсвийг Мэргэжлийн боловсрол, сургалтын Увс аймгийн салбар зөвлөл /цаашид “Салбар зөвлөл” гэх/ тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулна.” 1.4-д “Сангийн орлогыг бүрдүүлэх болон мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг сангаас санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг Салбар зөвлөл эрхлэн гүйцэтгэнэ.” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна. Цаашид Салбар зөвлөл нь батлагдсан хууль, журмын дагуу Увс аймгийн Мэргэжлийн боловсрол, сургалтын сангийн үйл ажиллагааг идэвхжүүлж ажиллахыг зөвлөмж болголоо.

2.2. Тухайн асуудал манай аймгийн түвшинд хамааралгүй байна.

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Сангийн хөрөнгийг төлөвлөхөд шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.
2. Увс аймгийн Мэргэжлийн боловсрол, сургалтыг сангийн “Салбар зөвлөл” нь аймгийн ИТХ-аас 2015 оны А/37 тоот тогтоолоор баталсан журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Зөвлөмж:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Улаангом политехник коллежийн дэд захирал Наранбилэгт зөвлөж байна.Үүнд:

1. Салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, “Увс аймгийн Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлж ажиллах.

Бүлэг 3: Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.1. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас 2015 онд Улаангом политехник коллежийн суралцагчдад нийт 638527.4 мянган төгрөгийн тэтгэлэгийг олгосон байна.

Үүнээс Засгийн газрын 2007 оны 294 дүгээр тогтоолын дагуу 2015 оны 10-р сар хүртэл 420603.7 мянга төгрөгийн тэтгэлэгийг Төрийн сан дахь Улаангом политехник коллежийн 150037401 тоот нэмэлт дансаар дамжуулан санхүүжүүлснийг 3,6,9,11 саруудад

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

/“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”/

суралцагчдын нэрийн дансанд шилжүүлж олгосон байна. Гэтэл Засгийн газрын 2007 оны 294 дүгээр тогтоолын 2.3-д “Сургууль нь суралцагчдын тэтгэлгийг сар бүрийн 3 дахь долоо хоногт бэлэн бусаар олгоно.” гэж заасныг зөрчиж 2-3 сарын дараа олгосон байна.

Харин Засгийн газрын 2015 оны 477 дүгээр тогтоолын дагуу 2015 оны 10-р сараас хойш “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”-гаас олгох тэтгэлэгийг Хөдөлмөрийн яамнаас суралцагчдын нэрийн дансанд шууд шилжүүлдэг болсон байна.

3.2, 3.3 дах асуудлуудын хүрээнд Увс аймагт тодорхой төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

3.4. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн санхүүжилт бүрэн олгогдоогүй байна.

2016 онд давхардсан тоогоор 4380 суралцагчдад “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”-гаас 301104.0 мянган төгрөгийн тэтгэлэг олгохоос 107203.3 мянган төгрөгийн тэтгэлэг олгож, 193900.7 мянган төгрөгийн тэтгэлэгийг 2016 оны 3-р сараас хойш олгоогүй байна. Энэ нь Засгийн газрын 2015 оны 477 дүгээр тогтоолын 3.3-д “... тэтгэлгийг суралцагчийн дансанд сар бүр шилжүүлнэ.” гэж заасныг зөрчиж байна.

Тэтгэлэг олгосон байдлыг судалгаагаар харуулбал дараах байдалтай байна.

“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”-аас Улаангом политехник коллежийн суралцагчдад олгосон тэтгэлэгийн судалгаа

он	сар	Хүүхдийн тоо				Олговол зохих тэтгэлэгийн дүн /мян.төг/	Олгосон зохих тэтгэлэгийн дүн /мян.төг/	Дутуу олгосон зөрүү /мян.төг/
		1-р анги	2-р анги	3-р анги	Нийт			
2015	1	563	332	33	928	62181.7	62181.7	0
	2	563	332	33	928	62181.7	62181.7	0
	3	563	332	33	928	62181.7	62181.7	0
	4	526	330	33	889	59768.6	59768.6	0
	5	524	327	33	884	59460.6	59460.6	0
	6	176	290		466	32620.0	32620.0	0
	9	472	349	272	1093	82209.4	82209.4	0
	10	477	347	272	1096	75360.3	75360.3	0
	11	425	348	272	1045	71582.5	71582.5	0
	12	419	347	272	1038	70980.9	70980.9	0
2015 оны дүн		4708	3334	1253	9295	638527.4	638527.4	0
2016	1	488	297		785	53595.2	53595.2	0
	2	484	296		780	53608.1	53608.1	0
	3	480	296		776	52734.3	0	52734.3
	4	479	295		774	53266.7	0	53266.7
	5	485	294		779	54079.9	0	54079.9
	6	202	284		486	33819.8	0	33819.8
2016 оны дүн		2618	1762	0	4380	301104.0	107203.3	193900.7

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

/”Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”/

2015, 2016 оны нийт дүн	7326	5096	1253	13675	939631.4	745730.7	193900.7
----------------------------	------	------	------	-------	----------	----------	----------

Түүнчлэн Улаангом политехник коллеж, ХЯ-ны санхүүжилтийн мэдээг тулган баталгаажуулахад гүйцэтгэлээр 2016 оны 3-6 сарын санхүүжүүлэх дүнгээс 709,6 мянган төгрөгийг дутуу олгосон мэдээ байна. Иймд ХЯ-тай суралцагчдын тэтгэлэг олгосон мэдээг тулган баталгаажуулах шаардлагатай байгааг зөвлөмж болгов.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хугацаа	Улаангом политехник коллежийн мэдээгээр тэтгэлэг олгох дүн	ХЯ-ны мэдээний дүн	Дутуу олгогдсон тэтгэлэгийн дүн
2015.12.31 үлдэгдэл	217923720	217923720	
2016 оны 1-6 сар олгогдох дүн	301104000	300394325	709675
Олгогдсон дүн	325127075	325127075	
Үлдэгдэл	193900645	193190970	709675

/төгрөгөөр

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Суралцагчдад нийт 193900.7 мянган төгрөгийн тэтгэлэг олгоогүй байна.
2. ХЯ-наас суралцагчдад олгох тэтгэлэгийн дүн 709.6 мянган төгрөгөөр дутуу байна.

Зөвлөмж:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.Үүнд:

Хөдөлмөрийн яаманд:

1. Суралцагчдын тэтгэлгийг журамд заасан хугацаанд нь олгож байх.

Хөдөлмөрийн яам, Улаангом политехник коллежид:

1. ХЯ-наас суралцагчдад олгох тэтгэлэгийн мэдээний дүнгийн зөрүүг тулган баталгаажуулах.

Бүлэг 4: Дотоодын хяналт үр дүнтэй байна.

4.1. Дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдсэн байна.

Улаангом политехник коллежийн сургалтын алба нь суралцагчдын ирцийн бүртгэлийг өдөр бүр бүртгэн, сарын эцэст ангийн журналтай тулган баталгаажуулж ХЯ-нд

хүргүүлдэг байна. Суралцагчдын тасалсан, өвчтэй, чөлөөтэй хугацаанд тэтгэлэгийг олгоогүй байна.

4.2. Сангийн үйл ажилагаанд мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт хийгдээгүй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 26.1-д “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.” гэж заасан байгаа боловч мэргэжлийн хяналтын байгууллага сүүлийн 4 жилд хяналт шалгалт хийгээгүй байна.

Харин Аймгийн засаг даргын дэргэдэх “Санхүүгийн хяналт, аудит”-ын алба 2016 онд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн боловч “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”-гийн үйл ажиллагааг хамруулаагүй байна.

4.3. Шилэн дансны тухай хууль хэрэгжсэн байна.

Улаангом политехник коллеж нь 2015 онд сангийн эх үүсвэрээс ирсэн санхүүжилт, зарлагын гүйлгээг Шилэн дансны сайт болон мэдээллийн самбарт байршуулсан байна.

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдсэн байна.
2. Сангийн үйл ажилагаанд мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт хийгдээгүй байна.
3. Шилэн дансны тухай хууль хэрэгжсэн байна.

Холбогдох байгууллагын санал


УВС АЙМАГ
УЛААНГОМ ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖ
213400, Улаангомын сум, Увс аймаг
Утас/Факс: (01-452)7045-3473

2016.10.10 № 1/134
Танай _____ -ны № _____ -ТООТ _____

Хариу хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангийн санхүүжилт, үйл ажиллагаанд хийж гүйцэтгэсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа санал нэгтэй байна.

Сангийн санхүүжилт нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаа боловч 2016 оны 03 сараас хойш засгийн газраас цаг тухайд нь санхүүжилт хийгдээгүй билээ.

Аудитаар өгөгдсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарал тавьж ажиллана.

ЗАХИРАЛ  ДБАТТОГТОХ

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

/”Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”/

Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны /”Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”/ үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналын хариу:

Холбогдох байгууллагаас нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй санал нэг байна гэсэн хариу ирүүлсэн тул тайлбар хийх шаардлагагүй болно.

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР
ШИНЖЭЭЧ

Т.НАМЖИЛ
Я.ЗУНГАРАВ